



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар A/358

Мандалговь

Г Шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8 дахь хэсэг, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 08-ний өдрийн A/191 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд гоц халдварт Шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад үхэр сүргийг бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов мэдээг хүргэн, бэлэн байдлыг хангуйж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
2. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарийг нэгдүгээр хавсралтаар, дархлаажуулалтын зардлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар, дархлаажуулалтын явцад хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах хуваарийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
3. Дархлаажуулалтын шатахууны зардал 13,880,200 (арван гурван сая найман зуун наян мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.
4. Шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг дуустал 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнийг зогсоох, мэдрэмтгий мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг хориглосугай.
5. Отормон нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавихыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
6. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (И.Жавхлант), захирамжийн хэрэгжилтийг хангуйж тайлagnаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очирт)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4822111198